

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.10 дахь хэсэг:

“3.10.Хувийн тэтгэврийн сангийн тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нь хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэртэй байна. Уг хэлбэрийн компанийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиар зохицуулах бөгөөд тус хуульд заагаагүй бусад харилцааг энэ хуулийн дагуу зохицуулна.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, заалт нэмсүгэй:

1/38¹ дугаар зүйл. Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа

“38¹.1. Хувийн тэтгэврийн сан гишүүдийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах, нэмэлт тэтгэврийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх зорилготой байна.

38¹.2. Нэмэлт тэтгэврийн хөрөнгө нягтлан бодох бүртгэлийн хувьд хувийн тэтгэврийн сангийн хөрөнгөөс тусгаарлагдсан байх ба нэмэлт тэтгэврийн хөрөнгийг кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад хадгалуулна.

38¹.3. Нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн дагуу зохицуулна.

38¹.3. Хувийн тэтгэврийн сан нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэртэй байна. Хувийн тэтгэврийн сантай холбогдсон харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиар зохицуулна.”

2/4 дүгээр зүйлийн 4.1.34 дэх заалт:

“4.1.34. “хувийн тэтгэврийн сан” гэж Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн 5.1.5-д заасан хуулийн этгээдийг.”

3/24 дүгээр зүйлийн 24.1.18 дахь заалт:

“24.1.18. хувийн тэтгэврийн сангийн;”

2 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.19 дэх заалтын “тэтгэврийн” гэсний өмнө “хувийн” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “24.1.12-т” гэснийг “24.1.12, 24.1.18-д” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.18 дахь заалтын дугаарыг “24.1.19” гэж, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “24.1.18-д” гэснийг “24.1.18, 24.1.19-д” гэж, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн “24.1.18-д” гэснийг “24.1.19-д” гэж, 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийн “24.1.18-д” гэснийг

“24.1.18, 24.1.19-д” гэж, 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “24.1.18-д” гэснийг “24.1.19-д” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт:

“3.1.11.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасан үйл ажиллагаа;”

2/6 дугаар зүйлийн 6.2.8 дахь заалт:

“6.2.8.хувийн нэмэлт тэтгэврийн чиглэлээр Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасан.”

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийн “Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл,” гэсний дараа “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн 16, 17, 18 дугаар зүйл,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын дугаарыг “3.1.12” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “тэтгэврийн сан,” гэсний өмнө “хувийн” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн Дөрөвдүгээр бүлгийн дараа доор дурдсан агуулгатай **ДӨРӨВДҮГЭЭР¹** бүлэг нэмсүгэй:

“ДӨРӨВДҮГЭЭР¹ БҮЛЭГ ХУВИЙН НЭМЭЛТ ТЭТГЭВРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ

20¹ дүгээр зүйл. Хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаа эрхлэх

20¹.1. Урт хугацааны даатгагч нь Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагаа эрхэлж болно.

20¹.2. Урт хугацааны даатгагч нь хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрөө Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу Зохицуулах хороонд бүртгүүлэх ба хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл давхар авахгүй.

20¹.3. Хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбогдуулан Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасан даатгалын мэргэжлийн оролцогчийн үйлчилгээ авч болохгүй.

20¹.4. Хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн дагуу зохицуулна.”

2 дугаар зүйл. Даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай 3.6 дахь хэсэг нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэг:

“3.6. Хувийн нэмэлт тэтгэвэртэй холбогдсон харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиар зохицуулна.”

3 дугаар зүйл. Даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсгийн дугаарыг “3.7” гэж, 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсгийн “3.1-3.5-д” гэснийг “3.1-3.6-д” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 46¹ дугаар зүйл нэмсүгэй:

1/46¹ дугаар зүйл:

“46¹ дугаар зүйл. Хувийн нэмэлт тэтгэвэр

46¹.1. Ажил олгогч нь өөрийн ажилтныг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу ажил олгогчийн тэтгэврийн хөтөлбөрт хамруулж болно.

46¹.2. Нэмэлт тэтгэврийн гэрээг хөдөлмөрийн гэрээнээс тусад нь Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу байгуулна.

46¹.3. Хувийн нэмэлт тэтгэвэртэй холбогдсон харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2.9 дэх хэсэг нэмсүгэй:

1/11.10 дугаар зүйлийн 2.9 дэх хэсэг:

“2.9.хувийн тэтгэврийн сан хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт доор дурдсан агуулгатай 11.33 дугаар зүйл нэмсүгэй.

1/11.33 дугаар зүйл:

“11.33 дугаар зүйл.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль зөрчих

1.Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, бүртгэл, эрхгүйгээр эрхэлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн танилцуулгад худал, дутуу, төөрөгдүүлсэн мэдээлэл тусгаж нийтэд танилцуулсан, эсхүл худал амлалт өгсөн, эсхүл танилцуулгад эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр аливаа өөрчлөлт оруулсан, эсхүл хуулийг зөрчиж эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй танилцуулгыг нийтэд танилцуулсан, эсхүл санхүүжилт татах зорилгоор бусад төрлийн мэдээллийг нийтэд нээлттэй зарласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Хуульд заасныг зөрчиж:

3.1.хувийн тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианы үйл ажиллагааны журам зөрчсөн;

3.2.хориглосон үйл ажиллагаа явуулсан;

3.3.хуулиар зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлж, эсхүл хуулиар зөвшөөрснөөс бусад төрлийн хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулсан;

3.4.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг хүчингүй болгох шийдвэр гарснаас хойш нэмэлт тэтгэврийн хөрөнгийг хуульд тусгайлан заасны дагуу шилжүүлэхээс өөрөөр захиран зарцуулсан;

3.5.кастодиан нь нэг нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн тухайд хөрөнгө оруулалтын менежментийн, кастодианы үйлчилгээг нэгэн зэрэг үзүүлсэн;

3.6.хөрөнгө оруулалтын менежментийн компани нь нэг нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн тухайд хөрөнгө оруулалтын менежментийн, кастодианы үйлчилгээг нэгэн зэрэг үзүүлсэн;

3.7.хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө оруулалтын зардлын төлбөрөөс бусад төлбөр, хураамжийг нэмэлт тэтгэврийн хөрөнгөөс гаргасан;

3.8.хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан журам, заавар, хувийн тэтгэврийн сангийн дүрэм, нэмэлт тэтгэврийн хөрөнгийг итгэмжлэн удирдах журмаар тогтоосон, хөрөнгө оруулалтын буюу эрсдлийн удирдлагын бодлогын баримт бичигт заасан, эсхүл гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа эсэхт нэмэлт тэтгэврийн хөрөнгийг гэрээгээр хадгалж байгаа кастодиан нь хяналт тавих үүргээ биелүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Хуульд заасан мэдээлэл, мэдэгдлийг зохих журмын дагуу холбогдох этгээдэд гаргаж өгөөгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Хөрөнгө оруулалтын менежментийн компани нэмэлт тэтгэврийн хөрөнгийг захиран зарцуулахтай холбогдсон хэлцлийг өөрийн нэрийн өмнөөс хийгээгүй, эсхүл итгэмжлэн удирдлагыг хэрэгжүүлж байгаа гэдгээ мэдэгдээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Хуульд заасныг зөрчиж:

6.1.хувийн тэтгэврийн сангийн дэлгэрэнгүй, эсхүл товчилсон тэмдэглэгээг хэрэглэсэн;

6.2.нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбоотой үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргасан;

6.3.эрх бүхий байгууллагаас эрх олгосон, хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөртэй холбоотой зар сурталчилгаа явуулсан;

6.4.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчтай байгуулах гэрээнд хуулиар, эсхүл хувийн тэтгэврийн сангийн дүрмээр хөрөнгө оруулалтын менежментийн компани, эсхүл кастодианы хүлээхээр заасан үүрэг, хариуцлагыг бууруулах, эсхүл чөлөөлөх тухай заалт тусгасан бол хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Татан буулгах комисс эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхөөс санаатайгаар зайлсхийсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2.9 дэх хэсгийн дугаарыг “2.10” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 44.9 дэх хэсэг нэмсүгэй:

1/44 дүгээр зүйлийн 44.9 дэх хэсэг:

“44.9.Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн энэ хуулийн 44.7.3-т заасан үйл ажиллагаатай холбоотой харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн дагуу зохицуулна.”

2 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.8 дахь хэсгийн “хувийн тэтгэврийн сангийн болон” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг:

“14.2.Энэ хуулийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн дагуу төлсөн шимтгэлийг албан татвар ногдуулах орлогоос хасч тооцох дүнгийн хэмжээ нь ажилтны албан татвар ногдуулах үеийн үндсэн цалингийн 20 хувиас хэтрэхгүй байна.”

2/25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг:

“25.7.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасан хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч байна. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу нэмэлт тэтгэвэр олгох тухай бүрт энэ хуулийн 25.1.2-т заасан журмын дагуу албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлнэ.”

3/28 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэг:

“28.6.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн 10.1-т заасан гишүүний төлсөн шимтгэлийн хувьд албан татвар төлөгчийн энэ хуулийн 27.2-т заасны дагуу хүргүүлсэн тайланг харьяа татварын алба нягталж, нийт төлсөн шимтгэлийн 10 хувийг буцаан олгоно. Татварын жилд буцаан олгох албан татварын дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 сард үржүүлсэнтэй тэнцэх мөнгөн дүнгээс хэтрэхгүй байна. Албан татварын буцаан олголтыг Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ. Албан татвар буцаан олгоход энэ хуулийн 28.4-т заасан журам нэгэн адил үйлчилнэ.”

4/9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт:

“9.1.5.хувийн нэмэлт тэтгэврийн орлого, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн 13.4-т заасан орлого.”

5/16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалт:

“16.1.5.хувийн нэмэлт тэтгэврийн орлогоос Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасан захиргааны зардал, хөрөнгө оруулалтын зардлыг хассан зөрүүгээр, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн 13.4-т заасан орлогыг нийт дүнгээр.”

6/22 дугаар зүйлийн 22.1.10 дахь заалт:

“22.1.10.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу ажил олгогчийн төлсөн шимтгэл, ажилтан, хувь хүнд олгосон баталгаат өгөөж, нэмэлт тэтгэврийн хөрөнгөд гишүүний тэтгэвэр тогтоолгох хүртэл хугацаанд үүссэн хөрөнгө оруулалтын өгөөж.”

2 дугаар зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “орлого,” гэсний дараа “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасан эрх залгамжлагч, өвлөгчийн нэг удаагийн тэтгэвэр хэлбэрээр олсон орлого;” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “нийгмийн даатгалын шимтгэлийг” гэсний дараа “, мөн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу төлсөн шимтгэлийг” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтын “хонжворын” гэсний дараа “, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасан эрх залгамжлагч, өвлөгчийн нэг удаагийн тэтгэвэр хэлбэрээр олсон” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтын “тэтгэвэр” гэсний өмнө “нийгмийн даатгалын” гэж, 25 дугаар зүйлийн 25.1.2-т “16.1.4” гэсний дараа “16.1.5” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “16.1.4,” гэсний дараа “16.1.5,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.1.15 дахь заалт нэмсүгэй:

1/15 дугаар зүйлийн 15.1.15 дахь заалт:

“15.1.15.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу ажил олгогчоос төлсөн шимтгэл. Ажил олгогчоос хасагдаж тооцох дүнг тооцохдоо Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 14.2-т заасныг баримтална.”

2/15 дугаар зүйлийн 15.1.16 дахь заалт:

“15.1.16.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу нэмэлт тэтгэврийн хөрөнгөд гишүүний тэтгэвэр тогтоолгох хүртэл хугацаанд үүссэн хөрөнгө оруулалтын өгөөж.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг:

“10.6.Энэ хуулийн 7.2.19-д заасан орлогод ногдох албан татвар ногдуулах хугацааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр олгосон өдрөөр тухай бүр тогтооно. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу гишүүн нэг удаагийн тэтгэвэр авах бол албан татвар ногдуулах хугацааг гишүүнд тэтгэврийн хөрөнгийг шилжүүлсэн өдрөөр тогтооно.”

2/16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг:

“8.5.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасан тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь энэ хуулийн 7.2.19-д заасан орлогод ногдох албан татвар суутган төлөгч байна. Албан татвар суутган төлөгч нь энэ хуулийн 7.2.19-д заасан орлогод ногдох албан татварыг дараа сарын 10-ны өдрийн дотор төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, баталсан маягтын дагуу тайлангаа харьяалах татварын албанд тушаана.”

3/7 дугаар зүйлийн 7.2.19 дахь заалт:

“7.2.19.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу нэмэлт тэтгэврийн хөрөнгөд гишүүний тэтгэвэр тогтоолгосноос хойш хугацаанд үүссэн хөрөнгө оруулалтын өгөөж.”

4/13 дугаар зүйлийн 13.5.20 дахь заалт:

“13.5.20.Хувийн тэтгэврийн сангийн үйлчилгээ;”

2 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “урамшуулалд” гэсний дараа “хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуульд заасны дагуу ажил олгогчийн төлсөн шимтгэлд” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “урамшуулалд” гэснийг “урамшуулал,” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалт:

“4.1.10.хувийн тэтгэврийн сан;”

2 дугаар зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “4.1.8” гэсний дараа “4.1.10” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.18 дахь хэсгийн “11.30” гэсний дараа “”11.33” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг